



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №36



2018 оны 10-р сарын 15-19

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **1235** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 109(8.8%) галзуугийн эрсдэлд өртсөн, 1091(88.3%) хачигт халдвар, 19(1.5%) бэтэг, 2(0.2%) хумхаа, 8(0.7%) боом, 6(0.5%) тарваган тахлын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:



Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Төв аймгийн 106 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын **1091** сэжигтэй тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14%-иар бага байна. Эпидемиологийн 41-р долоо хоногтой харьцуулахад 2 сэжигтэй тохиолдлоор илүү байна.



Хачигт риккетсиозын 811 сэжигтэй тохиолдлын 199(24.5%), хачигт энцефалитын 185 сэжигтэй тохиолдлын 32(17.3%), хачигт боррелиозын 95 сэжигтэй тохиолдлын 24(25.3%) тархвар судлал, эмнэлзүй, лабораторийн шинжилгээгээр тус тус онош батлагдсан байна

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Архангай, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт **109** тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17%-иар, эпидемиологийн 41-р долоо хоногтой харьцуулахад 3 сэжигтэй тохиолдлоор тус тус бага байна.




1.3 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

10 дугаар сарын 17-ны өдөр ХӨСҮТ-өөс бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй 7 тохиолдол бүртгэгдэж, лабораторийн шинжилгээ хийгдэж байна.

1.4 Мэрэгч амьтны дуудлага:

Нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ээс мэрэгч амьтны нийт 91 дуудлаганд үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс 15.4%-иар их байна.



Энэ 7 хоногт СХД, БЗД, ХУД-ээс ирүүлсэн 3 удаагийн амьтны (тарвага 17 ширхэг) дуудлагад үйлчилж, хураагдсан сорьцыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжилж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:

Багануур дүүргийн “Гурван хонгор” амралтын газар 10 дугаар сарын 17-ны 21:15 цагийн орчимд галзуугийн сэжигтэй 1 үнэг, 1 хурга үхсэн, 3 хурга өвчилсөн дуудлагын дагуу Багануур дүүргийн ЗӨСТ газар дээр нь очиж ажилласан.

Хариу арга хэмжээ:


- УМЭАЦТЛ-т сорьц дээжилж галзуу өвчний үүсгэгч илрүүлэхээр шинжилгээнд хамруулсан. Шинжилгээ үргэлжилэн хийгдэж байна.
- Ариутгал, халдваргүйтгэл хийсэн
- Голомтонд байгаа 1 өрх айлд сургалт сурталчилгаа хийгдсэн.

Эх сурвалж: Багануур ЗӨСТ

Олон улсад:

Эбола вирус халдвар:

Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад 10 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Хойд Киву мужийн (Mabalako, Beni, Kalunguta, Masereka, Butembo, Oicha, Musienene), Итури мужийн (Mandima) эрүүл мэндийн төвөөс нийт 220 сэжигтэй (185 батлагдсан, 35 болзошгүй) тохиолдол, үүнээс 142 нас баралт бүртгэгдсэн. 15-44 насны эмэгтэйчүүд илүүтэй өртсөн байна.



Зураг 1.БНАК, ЭВХ-ын тархалт

10 дугаар сарын 17-нд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь Эбола вирусийн дэгдэлтийн талаар ОУЭМД-ийн дагуу онцгой байдлын хорооны 1 дэх хуралаар эбола вирус халдварын дэгдэлтийн талаар ДЭМБ-ын ерөнхий захирал ОУЭМД-ийн дагуу онцгой байдлын хорооноос эхний удаагийн хуралдааныг зохион байгуулсан. Энэхүү уулзалтын гол зорилго нь БНАК улс дахь эбола вирус халдварын дэгдэлтийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл авах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг ярилцах,

ДЭМБ-ын ерөнхий захирал НЭМ-ийн онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх хууль дүрэм журам, бэлэн байдлаа хангасан эсэх талаар өөрийн үзэл бодлыг илэрхийлэх зорилготой.

Эх сурвалж: ДЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:

ОХУ-ын Ливнь хотын Орёл мужид Африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 12045 гахай өртсөнөөс, 4 нь өвчилж үхэн, 400 гахайг устган, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:


БНХАУ-ын Хунан мужид өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N6 вирүст халдвар 9 дүгээр сарын 26-нд бүртгэгдэж 1414 шувуу өртөмхий байснаас, 516 нь батлагдан, 385 шувуу өвчилж үхэн, 1029 шувууг устгаж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Африкийн гахайн мялзан өвчин:


Румын улсын Констанца хотын Влахи Алиман мужид африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 67 гахай өртсөнөөс, 1 нь өвчилж үхэн, 66 гахайг устгасан байна.



Эх сурвалж: ДАЭМБ


Мал амьтны боом өвчин:

Украин улсын Сарата хотын Одесса мужид мал, амьтны боом өвчин 10 дугаар сарын 12-нд бүртгэгдэж, 6 үхэр өртөмхий байснаас, 1 нь батлагдан, 1 үхэр өвчилж үхсэн байна. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоон ажиллажээ.



Африкийн гахайн мялзан өвчин:

Украин улсын Корець хотын Ровно мужид 10 дугаар сарын 10-нд африкийн гахайн мялзан өвчин бүртгэгдэж, 56 гахай өртөмхий байснаас, 1 гахай өвчилж үхэн, 55 гахайг устган, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин:


Вьетнам улсын Вак Лак мужид шувууны томуугийн H5N6 вируст халдварын дэгдэлт бүртгэгдэж, 2500 шувуу өртөмхий байснаас, 100 нь батлагдан, 100 шувуу өвчилж үхэн, 2400 шувууг устгасан байна. Тус мужид хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Шүлхий өвчин:

Израйль улсын Хазапон мужийн үхрийн аж ахуйд “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн шүлхий өвчин улмаас 24 үхэр өртөмхий байснаас, 5 үхэр өвчилсөн байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Энэ долоо хоногт Багануур Архангай, Өмнөговь, Хэнтий, Төв, Завхан, Ховд, Дундговь аймгийн ЗӨСТ-үүд үйл явдалд суурилсан тандалтын мэдээгээ илрүүлсэн байна. Салбар төвүүд ШУН-ийн eor@nczd.gov.mn хаяг руу мэдээгээ ирүүлж байна уу?